



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2010 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 01

Арвайхээр


Хөрөнгөнд үнэ тогтоож, худалдах тухай


"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 78 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутгийн өмчийн эд хөрөнгөнд үнэлгээ тогтоох комиссын хурлын шийдвэрийг үндэслэн худалдах хөрөнгийн үнийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Аймгийн Засаг даргын 2008 оны 207 дугаар захирамжаар үнэ тогтоон худалдахаар шийдвэр гарсан Баян-Өндөр сумын хүн эмнэлэг, Засаг даргын Тамгын газрын машинуудыг өөрсдийн байгууллагуудын хүсэлтээр хүчингүй болгож, Баян-Өндөр сумын хүн эмнэлгийн авто машиныг Тарагт сумын хүн эмнэлгийн авто машины сэлбэгээр, Баян-Өндөр сумын ЗДТГазрын усны машиныг засаж ашиглахыг зөвшөөрсүгэй.

Гурав. Дээрх хөрөнгийг худалдан борлуулж орлогыг Орон нутгийн өмчийн дансанд төвлөрүүлэхийг СЭЗБЗХэлтсийн дарга /Д.Нэмэхбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д. ТОГТОХСҮРЭН



Д/д	Сум, байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Худалдах үнэ
1	БГХӨСТөв	УАЗ 31514 маркийн ӨВА 22-06	400.0
2	Аймгийн ЗДТГазар	УАЗ 31514 маркийн ӨВА 35-98	400.0
3	Түшигдөлгөөн өрхийн эмнэлэг	Хонда мотоцикль	30.0
4	Хужирт сумын ЗДТГазар	УАЗ 31512 маркийн ӨВА 23-20	500.0
5	Хужирт сумын Эмнэлэг	УАЗ 31512 маркийн ӨВА 23-78	300.0
6	Хужирт сумын Эмнэлэг	Хонда мотоцикль	30.0
7	Баруунбаян-Улаан сумын ЗДТГазар	УАЗ 31512 маркийн ӨВА 28-08	200.0
8	Төгрөг сумын Эмнэлэг	УАЗ 31512 маркийн ӨВА 30-44	200.0
9	Бүрд сумын ЗДТГазар	УАЗ 31512 маркийн ӨВА 21-55	500.0
10	Хайрхандулаан сумын ЗДТГазар	УАЗ 31512 маркийн ӨВА 35-72	400.0
11	БСГазар	Галлопер-2 маркийн ӨВА 00-91	1570.0
12	Тарагт сумын Сургууль	ГАЗ-53 маркийн ӨВА 69-09	100.0
13	Цагдаагийн газар	УАЗ 31512 маркийн ӨВА 52-25	300.0
<b>ДҮН</b>			<b>4930.0</b>

